

5. Тайлантай ажиллах

Тайлан нь тухайн модулийн мэдээлэл дээр дэлгэрэнгүй комплекс анализ хийх боломжийг олгох ба цаг хугацааны давтамжтай мэдээлэл хадгалах дата агуулахтай холбогдож ажиллана.

Тайлантай ажиллахад дараах ойлголтуудыг мэдэх шаардлагатай. Үүнд:

- Тайлангийн зохион байгуулалт
- Тайлангийн бүтэц

Тайлангийн зохион байгуулалт

Тайлангийн зохион байгуулалт дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- **Тайлангийн каталогийн хиерархи**

Тайлан заавал нэг каталогт хамаарах ба нэг каталог нь нөгөө каталогтоо хиерахи байдлаар харъяалагдаж болно.

- Сонгогдсон каталог
- **Сонгогдсон каталогийн мэдээлэл**

Каталогийн хиерархиас каталог сонгоход тухайн каталогт харъяалагдах тайлан болон каталогийг харуулна.

- Сонгогдсон каталогийн нэр
- Хайлт, шүүлт хийх
- Харъяалагдах тайлан болон каталог

Тайлангийн бүтэц

Тайлангийн зохион байгуулалтын хэсгээс тайланг сонгоход дараах цонх харагдана.

Суралцагч нарийвчилсан мэргэжлийн чиглэлээр Буцах

Тайлан > Суралцагч > Мэргэжлийн чиглэл > ... Хэвлэх Татах Тохиргоо 100

Тайлангийн шүүлт

Ерөнхий мэргэжлийн чиглэл
All

Төрөлжсөн мэргэжлийн чиглэл

- Бүгд
- Боловсрол
- Урлаг
- Хүмүүнлэг
- Хэл
- Нийгмийн болон зан үйлийн шинжлэх у
- Сэтгүүлзүй, мэдээлэл
- Бизнес ба удирдахуй
- Эрхзүй
- Биологи ба холбогдох шинжлэх ухаан
- Хүрээлэн буй орчин

Нарийвчилсан мэргэжлийн чиглэл

- Бүгд
- Боловсролын шинжлэх ухаан
 - Багш, оургуулийн өмнөх насны боловср
 - Багш, бага ангийн боловсрол
 - Багш, мэргэжлийн
 - Дуу дүрсний техник болон медиа үйлдв
 - Хувцас загвар, интерьер ба үйлдвэрлэл
 - Дүрслэх урлаг
 - Гар урлал
 - Хөгжим, тайз дэлгэцийн урлаг
 - Урлагийн салбар дундын хөтөлбөр

Хүйс

- Бүгд
- Эрэгтэй
- Эмэгтэй

Боловсролын түвшин

- Бүгд
- Дипломын боловсрол
- Бакалаврын боловсрол
- Магистрын боловсрол
- Докторын боловсрол

Тайлан бодох

Шинэчлэх

СУРАЛЦАГЧДЫН ТОО НАРИЙВЧИЛСАН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2018-2019 оны хичээлийн жил

№	Мэргэжлийн чиглэл	Нийт	Үүнээс:		Боловсролын түвшин			
			Эмэгтэй	Эрэгтэй	Диплом	Бакалавр	Магистр	Доктор
Боловсролын шинжлэх ухаан								
1	Боловсрол судлал	3,106	2,561	545	0	157	2,455	494
2	Боловсролын удирдлага	1,679	1,461	218	0	0	1,679	0
3	Сургалтын технологи	24	23	1	0	0	24	0
Бүгд		4,809	4,045	764	0	157	4,158	494
Хувиар		100%	84.11%	15.89%		3.26%	86.46%	10.27%

Суралцагчдын тоо нарийвчилсан мэргэжлийн чиглэлээр Хуудас: 1

Тайлбар:

1. Тайлангийн толгойн мэдээлэл

Сонгогдсон тайлангийн нэр болон буцах товчлуур байх ба буцах товчлуур дээр дарахад өмнөх хуудасруу шилжинэ.

2. Тайлангийн дэд мэдээлэл

Тухайн тайлангийн байршлын мэдээлэл болон хэвлэх, татаж авах, тохиргоо хийх,... зэрэг тайлан дээр хийгдэх үйлдлүүдийг агуулна.

- 2.1 Тайлангийн байршил
- 2.2 Тайлан дээр хийх үйлдэл

3. Тайлангийн шүүлт

Тайлангийн мэдээллийг харуулахдаа тухайн тайлангаас хамаарсан нэмэлт хайлт, шүүлт хийх боломжтой. Шүүлт хийсний дараа **Тайлан бодох** товчлуур дээр дарж тайлангаа бодуулна.

Хэрэв хайлт болон шүүлтээ арилгах бол **шинэчлэх** товчлуур дээр дарна

- **3.1 Шүүлтийн төрөл**
- **3.2 Шүүлт хийх утга**
- **3.3 Тайлан бодох болон Шинэчлэх үйлдэл**